

ДЭЭД МОНГОЛ ГЭСЭР ДЭХ ЗАРИМ СОЁЛЫН ТАЙЛАМЖ

Дуранхуар

Түлхүүр үг : *Дээд монгол Гэсэр, өгүүлэмж, шүтлэг, зан үйл, соёл*

Аман зохиол нь аман урлаг гэгддэгийн хувьд соёлтой нягт холбоотой юм. Соёл нь аман зохиолын үндэс суурь болж аман зохиол нь соёлыг тусган, басхүү соёлд нөлөөлдөг. Хөхнуур төвдийн өндөрлөг бол “Гэсэр” туулийн бүрэлдсэн төрөлх нутаг юм. Дээд монголчууд бол “Гэсэр”-ийн соёлын өлгийд бүүвэйлэгдэж өссөн Монголын олон овог ястны нэг болох юм. Иймээс дээд монгол “Гэсэр” нь монгол “Гэсэр”-ийн чухал нэгэн хувилбар болно. Ямарваа улс үндэстэн, ястан нэг бүр өвөрмөц соёлын сэтгэхүйтэй байдаг. Дээд монгол “Гэсэр”-ийн соёл бол урт удаан хугацаанд тухайн нийгэм түүх, байгалийн орчин зэргээс шалтгаалж өвөрмөц онцлогтой болж хөгжиж иржээ. Дээд монгол “Гэсэр”-ийн туулийн зарим өгүүлэмжид соёлын тайламж хийхэд дээд монгол “Гэсэр”-ийн туулийн тархалтын түгээмэл ба өвөрмөц шинжийг тодруулах ёстой.

1. Дээд монгол “Гэсэр” дэх балар эртний шүтлэгийн тусгал

Нэг. Уул хайрханы шүтлэг

Уул хайрханы шүтлэг нь дээд монголын баатарлаг туульд тусгалаа олсон байдаг. Уул хайрханы шүтлэг бол дэлхийн олон үндэстэн угсаатны нэлээд эртний, балар эртний шүтлэг мөн. Тэгвэл дээд монголын аман зохиолын гол нуруу болж байх дээд монгол “Гэсэр”-т ч уул хайрханы шүтлэгийн ул мөр харагдаж байдаг. Жишээлбэл: Норжингийн хэлдэг “Гэсэр”-т *“Аманхөгжүүн эмгэн хэдэн ямаагаа хариулдаг юм байжээ. Нэгэн өдөр бороо болж (орж) эмгэн сайхь хэдэн ямаагаа туугаад хоргоддог хадныхаа хөндийд хүрчээ. Яг л хадныхаа хөндийд орох гэтэл хөндий дотор нэг их цагаан сахалтай хөгишин өвгөн сууж байжээ. Амахөгжүүн эмгэн “ээ гай үзэгдүүл” гэж айж цочиод ирэхэд эмгэний бие ч даруй хүндэрч эхлэв. Ингээд амандаа нөж зуугаатай, нэг гартаа нөж бариатай тийм нэг хөвгүүн гардаг”* гэдэг. Хэдийгээр туульд шууд хоёр настан уул хадыг тахиж байгаад үр олсон биш боловч, уул хадтай ямар нэгэн холбоотойгоос болоод хүүхэдтэй болсон нь мөн ч уул хайрханы шүтлэгийн ул мөр гэж хэлж болно.

Хоёр. Хад чулууны шүтлэг

Дээд монгол “Гэсэр”-т хад чулуутай холбоотой өгүүлэмж байгаа харагддаг. Хад чулууны шүтлэг бол чулуун зэвсгийн үеэс үлдэж уламжлагдаж ирсэн ардын аман зохиол дахь тусгалын ул мөр болно. Эртний үед хад чулуу нь хүмүүсийн ажил амьдралтай нягт холбоотой байсан учраас хүмүүс чулууг сэтчилж зарим нэг чулууг шүтээнээ болгон, дээдлэн биширснээс зүйл бүрийн хад чулууны шүтлэгийн соёл бүрэлдэн тогтсон байдаг. Тэгвэл дээд монголын “Гэсэр”-ийн туульд ч энэхүү хад чулууны шүтлэг нь тусгалаа олсон байдаг. Жишээлбэл: С.Хуягтын “Гэсэр”-т *“Гэсэр хаан хадтайгаа хоёулаа цагаан чулуун дээр “ум мани бадмэ хүм” гэж бичсэн тэр чулуугаар дарж тавиад 13 толгойт мангасыг дарав”*

гэдэг. Дарханы “Гэсэр”-т *“Гэсэрийн ээж нь Гэсэрийн хүйсийг огтолж чадахгүй ядарсанд Гэсэр: “Эх, миний хүйг даах юм байхгүй, баруун хойд голд хар цагаан хоёр хавтгай чулуу бий. Харыг нь дор нь тавьж, цагааныг нь хариуулвал сая миний хүйг даах байх юм” гэхэд ээж нь хэлсэн ёсоор болсонд огтолж хаясан гэнээ*” гэж хүүхдийн хүйсийг чулуугаар огтолж хаясан дүрслэл гардаг.

Эдгээр нь бүгд хад чулууны дүрслэлийн “Гэсэр”-ийн тууль доторх тусгал мөн болно. Энэ нь чулууг ямар нэгэн далдын хүчтэй юм гэж үзэн, түүнийг дээдлэн шүтсэн чулуун шүтлэгтэй холбоотой балар эртний хүмүүсийн балархай танилт мөн. Энэ дашрамд чулуун дээр *“ум ма ни бадмэ хум”* гэж бичиж мангасыг дарлаа гэснээс жирийн шашны үзэл санаа нэвтэрч байна.

Гэсэр баатар мангасыг чулуун доор дарсан өгүүлэмж нь “Гэсэр”-ийн нутаг усны үлгэрт бас гардаг. Миний бие Хөхнуурт хээрийн шинжилгээ хийж байх хугацаанд Гэсэрч Ням *“Мангасыг дарсан үхэр хар чулуу”* гэсэн үлгэр ярьж өгсөн билээ. *“Хөхнуурын Улаан шяны Зэрэг сум явах зам зуур Гашиун хавцалын эхэнд Гэсэрийн цагаан ямаанаас бас цаашид хар чулуу хавцалын эхэнд байдаг. Энэ нь Гэсэр алтан цагаан сэлмээрээ мангасын хүзүүг тас цавчиж, бие толгойг нь салгаж, голын хөвөөнд байгаа том хар үхэр чулуугаар толгойг нь дарж тавьсан гэнэ. Бас тэр үхэр чулуу унах цагт мангас дахин босох юм гэнэ”* гэж ардын дунд уламжлагдаж байна. “Мангасыг дарсан үхэр хар чулуу” гэх үлгэр нь дээр дурдсан Хуягтын “Гэсэр”-ийн өгүүлэмжээс ашигласан юм уу, Гэсэрийн туулийг хайлагчид нь Гэсэрийн туульд аяндаа оруулан авсан байж ч магад. Юутай ч харилцан нөлөөлсөн нь илэрхий байна. Гэсэрч Ням бас *“Гэсэрийн чулуу цагаан ямаа”* гэсэн үлгэрийг ярьж өгөв. Эрт урьд цагт Гэсэр богд хаан гэрээсээ гараад, алсын уулаар ан гөрөө хийхээр явж гэнэ. Тэр өдөр Гэсэр хааны ямаан сүрэг нь Зэргийн уулаар бэлчиж байв гэнэ. Түүнийг үзэхүйд хар мангас шүлсээ гоожуулан нэг цагаан ямааг нь дайран оржээ. Тэгсэн тэр цагаан ямаа нь ишгээ дагуулаад дутааж нэг бүдүүн хар чулуунд шингээд орж гэнэ. Энэхүү хад чулууг *“Чулуу цагаан ямаа”* гэдэг. Тэр чулууг холоос харахад үнэхээр нэг цагаан ямаа ишгээ хөхүүлээд зогсож байсан ором харагддаг. Миний бие Хөхнуурт хээрийн шинжилгээ хийх хугацаанд тусгайлан энэ хадны нүүр дэх мангасыг дарсан чулууг хүрч үзсэн юм. Нутгийн хүмүүс тэр хадан дээрх *“Гэсэрийн цагаан ямаан чулуун”* дээр хөх хадаг тавьснаас үзэхүл энэ чулууг тахиж байх нь эргэлзээгүй. Дээд монгол Гэсэрийн нутаг усны домогт иймэрхүү чулуутай холбоотой *“Гэсэрийн үлгэр”* нилээд арвин байдаг. Энэ нь эртний хүмүүс онцгой дүрстэй хад чулууг ямар нэгэн ид шидтэй гэж үздэгтэй холбоотой юм. Иймэрхүү дээд монголчуудаас нийт ойрад монголчуудын үлгэр туульд Гэсэр мангасыг алсны хойно хүүрийг нь заавал үхэр хар чулуугаар даруулж байдаг дүрслэл түгээмэл уламжилсан байдаг нь ойрадуудын дотор чулуун зэвсгийн үеэс нааш хад чулууны шүтлэг үе дамжин удаан үргэлжилсээр байгааг гэрчилж байна.

Гурав. Сүнсний шүтлэгийн тусгал

“Аливаа бүхэн сүнстэй” гэх ойлголт бол дэлхий нийтийн олон үндэстэн, овог аймаг, хамгийн дээд үе, балар эртний шүтлэгийн илрэл мөн. Эртний хүмүүс байгалийн үзэгдлийг тайлбарлаж чадахгүй учраас аливаа бүхэн сүнстэй гэж үздэг байв. Дээд монгол “Гэсэр”-ийн тууль ба үлгэрт иймэрхүү балар эртний шүтлэгийн сүнсний тухай ойлголтын ул мөр харагдаж байна. Дээд монгол “Гэсэр”-ийн тууль буюу үлгэрт гардаг мангас бүр амин сүнстэй бөгөөд тэр мангасын сүнс нь үргэлж ондоо юманд оршдог байна. Баатар урьдаар мангасын гадна оршиж байгаа амин сүнсийг нь асуугаад дараагаар сая мангасыг алдаг. Жишээлбэл: Норжингийн хэлдэг *“Гэсэр”-т “Гэсэр мангасын гэрт ирж хатнаа аврахаар ирсний хойно хатнаасаа мангасын амь нь аль аль байдаг буй гэж асуувал, хатан нь: “Энэ өмнө байдаг гурван ууланд нэг амь нь байдаг байна. Энэ хоёр хүрэл хайсанд нэг амь нь байна. Энэ тотго дээр нэг амь нь байна. Баруун уулын хуврагад байдаг хоёр хар буганд нэг амь нь байна” гэж хариулахад, Гэсэр тэдгээр амийг нь тасалдаг. Ингээд мангас харьж ирсэн хойно хатнаасаа: “Манайд хүн хар ирэв үү, үгүй юү. Хар багийг сураад идсэн чинь багалуурт ирчих шиг болов”* гэж дүрсэлдэг. Дээрх өгүүлэмжээс үзвэл, мангасын гадаад амиудыг нь устгаж хаяхад, мангас

хэдийгээр үхэхгүй боловч, мангасын хүч чадлыг нэг хэмжээгээр бууруулж харуулж байна.

Үүнээс гадна, тус үлгэрт бас мангасын гол амь нь алтан хайрцаг дотор байдаг алтан, мөнгөн хоёр могойгоор дүрслэгддэг. Гэсэр баатар дээрх гадаад амь ба гол амийг нь устгаж хаяад хамаг сүүлд нь мангасыг алдаг юм.

2. Дээд монгол “Гэсэр” дэх зан үйлийн тусгал

Нэг. Шүмэр дүйцүүлэх ёсны тусгал

Дээд монголчуудын баатарлаг туульд “шүмэр” гэдэг хэллэг олон удаа гардаг. Цагаанхүүгийн “Гэсэр”-ийн туульд “Гэсэр богд гунан хар мориндоо гарьдыг бүхлээр нь бөгтөргөн, найман түмэн мянган адууг дагаад ирэхэд нь баруун хойморь нь хар дэвсгэр дэвсэж хар шүмэр өрж, зүүн хоймор нь цагаан дэвсгэр дэвсэж цагаан морь тавьж, цагаан шүмэр өрж, цагаан цай тавиад ус шиг үйл бүтээсэн дүү чамдаа бэлгэтэй ерөөлтэй зүүн хоймор зориуллаа” гэж байдаг.

Нямын хэлсэн “Гэсэр”-ийн туульд бол туульч *“их хөвгүүн хангарьдыг бариад адуугаа дагаж ирэхэд замд ирээд хүргэн ахыг нь нөгөө тамд унагахаар зөвчилж, дүү минь цагаан үйл хийгээд ирсэн юм чинь цагаан шүмэрийн ард суу”* гэдэг.

Эдгээр өгүүлэмжээс үзэхэд “шүмэр” бол идээ ундааны зүйл бөгөөд хүндэтгэн барих дээжийн зүйлийг заасан ба басхүү хар цагаан өрөл гэж хувааж байдаг нь сонирхолтой байна. Шүмэр гэдэг нь дээд монголчуудын орон нутгийн өвөрмөц хэллэг юм. “Шүмэр” гэдэг энэ үгийн утгаас авж үзвэл төвд гаралтай үг юм. “Шү” гэдэг нь гурилыг зааж, “мэр” гэдэг нь тосыг зааж байна. Үүнээс үзэхэд шүмэр гэдэг энэ идээ нь төвд үндэстний нөлөөгөөр орж ирсэн зүйл бөгөөд “шүмэр”-т холбоотой ёс заншлын зүйл нь ч аажмаар дээд монголчуудын дунд буй болсон гэж үзэж болох юм. Одоогийн амьдралтай холбоотойгоор үзвэл, шүмэр нь дээд монголд ямар нэг уламжлалт найр дурсгалын өдөр эсвэл хурим чуулган дээр тахиж ирэх буюу дайчлуулахыг хүндэтгэн үзэж ёсчлон гүйцэтгэдэг заншил болсон байдаг. Бүх л сахиус зэргээс гадна бас шүмэр, архи, цайны дээж ч дээдлэгдэж байдаг. Түүнчлэн шүмэрийг даяарт хүртээхийг буян хүртэж буй хэмээн олзуурхан хүлээн авдаг уламжлалтай.

“Гэсэр”-т болгосон гурилыг тусгай тавганд Сүмбэр уулын хэлбэр бүхий шөвгөр хэлбэртэйгээр дөрвөн талд нь дөрвөн хэсэг ордолжин хэлбэртэй тос зүсэж босоо хэлбэрээр наагаад орой дээр нь нэг хэсэг тосоор чимж тавьдаг. Савны сууринд дүүрэн өрөм тавиад Сүн далайн төлөөлөл болгодог ёсон буй. Сүмбэрийн бүтэц яг сүмбэр уулын шовх оройн хэлбэртэй байж, Монголчуудын оюун санаанд эрхэм дээд ариун сайхны бэлэгдэл болж дээдлэгдэж байдаг. Шүмэрийн төлөөлж байгаа Сүмбэр уул нь бичиг сурвалжаас үзвэл тэр цаг үеийн Энэтхэгийн үлгэр домогт гардаг Сүмбэр уулаас эх үүсвэртэй байж шашин шүтлэгтэй холбоотой юм. Энэ утгаараа шүмэр нь анх эхлээд дээд монголчуудын бурхан шашныхны дунд хэрэглэдэг байснаа яваандаа аж амьдралд дэлгэрсэн байж болох юм. Дээд монголчуудын орчин тойрон хийгээд нийгмийн харилцаанаас Энэтхэг-төвдийн бурхан шашны нөлөөнд орох явцдаа Сүмбэр уулын тухай ойлголт ухамсар, уран санааны талаар түүнийг хүндэтгэн биширч дээдлэн шүтэх болж иржээ. Нэн эрт дээд үеэс нар, сар, уул усаа далдын хүчтэй гэж тахиж байсан монголчуудад Сүмбэр уулын сонин гайхамшигт үлгэр нь тэдэнд бодит болжээ.

Хоёр. Эрүү толгой заадаслах ёс

Дээд Монгол “Гэсэр” бол дээд монголчуудын ард түмний оюун ухааны бүтээгдэхүүн мөн. Дээд монгол “Гэсэр”-ийн тууль буюу үлгэр домог дотор дээд монголчуудын өвөрмөц онцлогтой зан заншлын тусгал үлэмж олон харагддаг. Түүний нэг болох эрүү толгой заадаслах ёсны тухай өгүүлбэр. Энэхүү заншлын тухай өгүүлэмж дээд монгол “Гэсэр”-т олон байдаг. Жишээлбэл: С.Хуягтын “Гэсэр”-т: *“Арван хоёр толгойт арзгар хар мангас “би хошуугаар амьтан, аймгаар албатыг залгадаг байгаад чам шиг баастай муу жош*

(басамжилсан үг)-ийг нь залгиж ядах юу байхав” гээд залгижээ. Хөвгүүн багалуур (багалзуур)-т нь хөндлөн сууж орхижээ. Арван хоёр толгойт арзгар хар мангас бархирчээ. Хөвгүүн “сайн эр бол өдрийн сайныг өнжин хүлээдэг билээ. Сарын сайныг сахин хүлээдэг билээ. Энэ ямар сайхан орон бэ. Би дээдийн оронд хааны тайж болж явлаа. Ийм сайхан орныг үзсэнгүй. Доордын оронд хөвнүүн болж явлаа. Ийм сайхан орныг олж үзсэнгүй” гэжээ. Тэгээд цагаан сарын шинийн нэгнээ тэр хөвгүүн 12 толгойт арзгар хар мангасын эрүү толгойг зааж гарч ирэн ээжтэйгээ золгожээ. ”

Үүнээс гадна “Гэсэр мангасын хоолойнд нь хүрч замилан суугаад мангасын гол амийг нь бууруулж байгаад сунайн босоход мангасын эрүү толгойг заадаслаж гэнэ. Ингээд мангасын толгойг тайраад бурхандаа тахисан гэнэ” гэх мэт дээд монгол Гэсэрийн домог яриа ч байдаг байна.

Эдгээр өгүүлэмжид гардаг эрүү толгой заадаслах ёс бол дээд монголчуудын энгийн амьдралд байдаг зан үйл мөн. Дээд монголчууд хурим найр буюу битүүний шөнө эсвэл цагаан сарын шинийн нэгэнд хонины толгой хуйхлож амыг нь заадаслаж дотор нь өвчүү цээж тавин, бурхандаа тахидаг ёслол нь даруй дээрх мөн. Дэлгэрүүлэн өгүүлбэл, эрүү толгой заах гэдэг нь дээд монголчууд битүүний орой битүү толгой зуламлан хуйхалж битүү тавиад шинэ жилийн шинийн нэгний өглөө нар гарахтай зэрэг үүдэн босго дээрээ битүү толгойгоо зааж “он жил хагацав, эрүү толгой заав” гэж шинэ жилийн хамаг анхны битүүг хагалж ёслол хийдэг байна.

Нутгийн настайчуудын ярихаар, эрүү толгой заадаслах заншил нь толгойн дээд тал нь шинэ жилийн сайн сайхныг бэлгэдэж, хар барцадыг арилгаж байдаг гэж нилээд хүндэлдэг байжээ. Амьтны толгойгоор тахилга барьдаг нь монголчуудын нилээд эртний уламжлалтай холбогдоно. Ойролцоо заншил хорчинд ч байдаг. Хорчингууд бол битүүний өглөө хоймор болгодог авдар хоргын дээр уур савссан гахайн толгойг гаргаж тавиад дээр нь хутга хатгаж өмнө нь гурван хундага архи шатаана гэдэг. Энэ нь хорчингуудын тариалах соёлын нөлөөгөөр хувирсан ёс байна. Гэхдээ амьтны толгойгоор тахидаг монголчуудын уламжлалт соёл, сэтгэхүйн ул мөр гэж болно. Энэ нь монголчуудын амин сүнс нь толгойдоо оршиж байдаг гэж сэтгэгдгээс ирэлтэй гэлтэй.

3. Дээд монгол Гэсэр дэх нийтлэг өгүүлэмжийн тухай

Дээд монгол Гэсэрийн ихэнх хувилбарт хатнаа аврахад хүрээд мангастай тулалдахад Гэсэр юм уу мангасын хөл дор нь юм шидэж дайснаа дардаг өгүүлэмж байдаг. Жишээлбэл, С.Хуягтын Гэсэрт: “Арван хоёр толгойт атгар хар мангас: Алу мэргэн чи өстнийхөө дор буурцаг цацаж, ачитныхаа дор хивс дэвсэж хивэг асга” гээд Гэсэртэй бие биеэрээ барилдаж эхлэв. Алу мэргэн хатан Гэсэрийн хөлд хивс дэвсэж хивэг асгаад, арван хоёр толгойт атгар хар мангасын хөлд буурцаг цацсанд Гэсэр түүнийг буурцаг дээр хальтруулж дунд чулуун чөмгийг нь тас хаяжээ” гэх өгүүлэмж байдаг.

Дээд монголын тууль “Догшин хар баатар”-т бас иймэрхүү өгүүлэмж буй. Мөн Шинжааны ойрдын үлгэрт иймэрхүү өгүүлэмж гардаг. Гэтэл бас энэ хэллэг нь төвд “Гэсэр”-т харагддаг юм. Харин Бээжин барын “Гэсэр”-т тариаг монголжуу амьдралд ойртуулж хонины хорголоор сольсон байдаг. Энэ нь өмнөх нь тариаланч амьдралыг илүү тусгаж, хойнох нь малжих амьдралтай илүү ойр байхыг харуулж буй.

Энд хэлж байгаа буурцаг тариа нь Хөхнуур, Төвдийн өндөрлөгт ургадаг орон нутгийн онц гаралтын нэг хөх тариаг зааж буй болно. Энд суурьшиж байгаа аль үндэстэн ч гэсэн хөх тариагаар энгийн амьдралд элдэв зүйлийн хоол унд хийдгээс ийнхүү үлгэрч нар туульд идээшүүлэн оруулж туулийн өвөрмөц онцлогийг товойлгосон байна. Ямарваа нэг үндэстний соёл нь харь соёлын нөлөөлөлтэй. Нэг үндэстэн ястны өвөрмөц онцлог бүхий ёс заншил, соёл бүрэлдэн тогтохдоо өөрийн уламжлалт соёлын хөрсөн дээр бат суурилж хөгжих

мөртөө мөн бусад үндэстний соёлоос зохих шим тэжээл хүртэж өөрийн үндэстний соёлоо баялагжуулан хөгжүүлдэг. Тиймээс ч “Гэсэр”-ийн төрөлх нутаг, “Гэсэр”-ийн соёлын хүрээнд монгол, төвд, монгол соёлын харилцаа нөлөөлөлцсөн соёлын үзэгдэл арвин байна.

Дүгнэлт

Дэлхий дахинд алдар цуутай баатар тууль “Гэсэр” бол Монголын ард түмний урт хугацааны амьдрал тэмцлийн явцдаа хамтаар бүтээсэн үндэстний түүх соёлын өв хөрөнгө болно. Монгол “Гэсэр” нь монгол үндэстний эртний уран зохиолын “Гурван оргил”-ийн нэг болж байдаг бөгөөд монгол “Гэсэр”-ийн тарсан хүрээ хэмжээ өргөн, нийт монголчуудын дунд өргөн уламжлагдсан билээ.

Дээд монгол “Гэсэр”-ийн туулийн тухай Б.Бөхчулуу, Ү.Шинэбаяр, Х.Цэрэнбал зэрэг эрдэмтэд анхаарлаа хандуулж судалгаа хийж өөрийн үзэл саналаа товч ба дэлгэрэнгүйгээр дурдаж тус туулийг судалгааны эргэлтэд оруулан олонд таниулсан байна. Миний бие эдгээр эрдэмтдийн судалгаанд суурилж, өөрийн хээрийн шинжилгээгээр баяжуулж, тус өгүүллийг бичсэн.

Дээд монгол “Гэсэр”-ийн тууль нэлээд олон талаар төвд “Гэсэр”-ийн биш, өөр эхээс нөлөөтөж зохиогдсон шинжтэй. Гэвч, тэр үндэстний аман зохиол нь энэ үндэстний дунд уламжлагдан дэлгэрэхдээ түүний хуулбар төдий болдог биш, харин энэ үндэстэн нь өөрийн амьдралын арга маяг, зан заншил, хайр сэтгэл, гоо сайхны дур сонирхол ба соёлын удамшил зэрэгтэй тохируулан дахин бүтэж, өөрийн үндэстний ард түмний онцлогтой болгодог юм. Иймээс дээд монгол “Гэсэр” нь зарим талаар төвд “Гэсэр”-ийн нөлөөтэй байх боловч бас биеэ даасан монгол үндэстний онцлогтой юм. Дээд монгол оронд төвд “Гэсэр”-тэй цуг зэрэгцэн монгол “Гэсэр”-ийг дууриаж ярьж байжээ. Ингэхдээ зарим монгол туульсийг Гэсэрийн бусад баатрын үлгэр болгон ярьдаг. Зарим туульчид нь өөрийн авьяасаа бадруулан, монгол туульсын зарим үйл явдлыг ашиглан төвд “Гэсэр”-ээс ихээхэн ялгаатай монгол “Гэсэр”-ийг урлан боловсруулж байв. Жишээлбэл: “Амин мэргэн Гэсэр богд”, “14 настай Гэсэр богд хаан ба 13 настай Авай анчин баатар”, “7 настай Дорж цэцэн хаан”, “Тугалчин хүү”, “Бурхан хар морьтой Гэсэр хаан”, “Гунан хар морьтой Гэсэр хаан”, “Догшин хар баатар” гэх мэт. Төвд “Гэсэр” бол дээд монгол туульсын агуулгыг улам баяжуулсан байдаг бол язгуурын дээд монгол туульс нь дээд монгол “Гэсэр” буй болоход хөрш шороо нь болж өгсөн юм. Цаашлаад энэ нь Гэсэрч ба “гэсэр” цуглуулагчийн хамтын бүтээгдэхүүн болжээ.

1716 онд хэвлэгдсэн “Бээжин барын Гэсэр” бол монгол “Гэсэр”-ийн хамаг анхны бичмэл “Гэсэр” гэж үзэж байна. Миний бие “Бээжин барын Гэсэр”-ийг агуулга ба уран дүр зэрэг талаас харьцуулж үзсэн. Үүний дүнд дээд монгол “Гэсэр” ба “Бээжин барын Гэсэр”-ийн нэг, дөрөв, тавдугаар бүлэгтэй төсөрхүү байж тэдгээр нь төвд “Гэсэр”-ээс орчуулсан авсан агуулга болно. Эдгээр нь төвд “Гэсэр”-т угаасаа байсан зүйл болно. “Гэсэр” урьдаар дээд монголчуудын дунд амаар уламжилж даруй төвд, монгол хоёр хэлтэй туульчид төвд “Гэсэр”-ийг орчуулж ярьж байсан байна. Ер нь тууль нь амаар урьдаар уламжлан дэлгэрч дараа нь бичгээр зохиогддог. Өөрөөр хэлбэл дээд монгол “Гэсэр” нь анхны монгол “Гэсэр” байх ёстой. Иймээс дээд монгол “Гэсэр” нь “Бээжин барын Гэсэр” ба төвд “Гэсэр”-ийн хооронд гүүр болж, өвөрмөц онцлогтой дээд монгол “Гэсэрийн тууль” ч болж чадсан байна.

Дээд монгол “Гэсэр”-ийн тууль нь эртний монголын байгал шүтлэгийн нөлөө шууд ба дамаар тусгагдсанаар барахгүй сүүлийн үеийн шарын шашны нөлөө жич одоо үеийн дээд монголчуудын зан үйлийн ёс зэрэг зан үйлийн соёл үзэгдлүүд ч дүрслэгдсэн явдал нь нэг талаар туулийн агуулгыг баялагжуулахын хамт нөгөө талаар бол дээд монголчуудын газарзүйн онцлог ба хамтын зан үйл зэрэг зүйлс тогтворжин хэвшсэнээс туулийн орон нутгийн онцлогийг бүрдүүлж чадсан байна. Монголчуудын уугуул шашин болох бөө мөргөл

мөн нөлөөлж ууланд амьдарч байсан дээд монголчууд уул хад ямар нэг сахиустай гэж үздэг. Бас шарын шашны нөлөө дээд монгол “Гэсэр”-т тусаж туулийн агуулга хэлбэр, зохиомж төгөлдөржихөд үүрэг гүйцэтгэжээ. Жишээлбэл, туульд “ум ма хум ном унших”, “өглөг өгөх” зэрэг зан үйл гардаг. Энэ нь дээд монгол “Гэсэр”-ийг хайлж байгаа Гэсэрч нар ихэнх нь лам гаралтай бөгөөд дээд монголчууд төвд үндэстэнтэй хөрш саахалт сууж, маш эртнээс шарын шашныг шүтсэнээс болон мөн зэрэгцэн оршиж амьдарсаар ирсэн төвд үндэстний ёс заншлын зүйлийг аяандаа хүлээж авсан нь бас харагдаж байна.

Номзүй

- Бүрэнтөгс.** 1999. *Монгол зан аалийн нэвтэрхий толь* (Оюуны боть). Өвөр Монголын Шинжлэх Ухаан Техник Мэргэжлийн Хороо.
- Гүрлэш, Зоригт нар.** 2003. *Хорчин зан үйлийн соёл судлал*. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хороо.
- Дамиранжав Б.** 2006. *Ойрадын баатарлаг үлгэрийн судлал*. Үндэстний Хэвлэлийн Хороо.
- Дүвчин С.** 1998. *Монголчуудын баатарлаг тууль*. Үндэстний Хэвлэлийн Хороо.
- Дуранхуар.** 2012. *Дээд монгол Гэсэр жич Гэсэрчийн судлал*. Диссертаци. Бээжин.
- Өлзий Т.** 1997. *Эртний монголчуудын соёл сэтгэхүй*. Өвөр Монголын Их Сургуулийн Хэвлэлийн хороо.
- Үсрэнгүй Л.** 2003. *Хөхнуурын монгол Гэсэрийн домог*. Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн хороо.
- Үсрэнгүй Л.** 2008. *Дээд монголын ардын аман зохиолын чуулган*. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо.
- Сарангэрэл.** 1998. *Тууль Жангар ба монгол соёл*. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо.
- Сарангэрэл.** 2011. *Монгол угсаатны заншил соёлын үндэс*. Үндэстний Хэвлэлийн хороо.
- Сэцэнцогт.** 1988. *Монгол үгсийн язгуурын толь*. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо.
- Хөхнуур Гэсэрийн тууж-2*. Өвөрмонголын “Гэсэр”-ийн ажиллах дугуйлан. 1986.
- Цэрэнбал Н.** 1990. *Догшин хар баатар*. Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн хороо.
- Чойдандар.** 1999. *Ойрадчуудын архи барих ёс хийгээд ардын нийтлэг ба орон нутгийн шинж*. “Ойрад судлал”.